



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/04

Номгон

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн
хугацаа сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.17, 19.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 12 дугаар зүйлийн 12.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 6, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдүгээр хурлын шийдвэрийн дагуу хугацаа сунгах байгууллагын мэдээллийг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, холбогдох стандарт, дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комиссын ажлын алба, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн (О.Найгалмаа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ДХАГВА-ОЧИР



642001008

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 18-ны
өдрийн 01/1 дүгээр тушаалын хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллага

№	Хуулийн этгээд, байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1	2	3	4	5
1	“Залаа амин дэм” ХХК-ийн Залаа амин дэм эмийн сан ЭСХ-23/03/001 (Улсын бүртгэлийн регистрийн дугаар: 3143414)	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх (Хоёрдугаар зэрэглэл)	Баянхонгор аймаг Шинэжинст сумын Эхэн хавцгай 4-р баг, сүлд толгой 1-303 тоот	2031.01.24 5 жил
2	“Хасбуу очир” ХХК-ийн Гоо фарм маркет эмийн сан ЭСХ-22/03/005 (Улсын бүртгэлийн регистрийн дугаар: 3142132)	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх (Нэгдүгээр зэрэглэл)	Баянхонгор аймаг Баянхонгор сумын Лувсанданзан жанцангийн өргөн чөлөө 4-436-1	2030.12.30 5 жил
3	“Дүүрэн тун” ХХК-ийн Дүүрэн тун эмийн сан ЭСХ-22/03/004 (Улсын бүртгэлийн регистрийн дугаар: 3143007)	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх (Хоёрдугаар зэрэглэл)	Баянхонгор аймаг Бууцагаан сумын Цагаан булаг 4-401 тоот	2030.12.30 5 жил